



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/12

Модот

Гүйцэтгэлийн үнэлгээний ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам" 25 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/115 дугаар тушаал, Аймгийн боловсролын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах багш нарын нэрийг 1 дүгээр хавсралтаар, зохион байгуулах багийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар, ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургууль дээр гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу шударга хариуцлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үнэлгээ бодитой хийгдэж буй эсэхэд хөндлөнгийн ажиглалт, хяналт шинжилгээ хийх тайлан мэдээг Боловсролын ерөнхий газарт хүргэх ажлуудыг хийж гүйцэтгэхийг ажлын хэсэг (Д.Ариунаа)-д даалгасугай.


3. Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг сургуулийн түвшинд зохион байгуулах удирдамжийг баримтлан нэгдсэн зохион байгуулалтаар ханган, анги танхим техник хэрэгслийг бэлтгэх, үнэлгээний нарийвчилсан зураглал гарган эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд мэдээлэн аливаа ёс зүйн зөрчилгүй ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ




Д.ОТГОНДУЛАМ

Ерөнхий боловсролын сургуулийн
захирлын 20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын ... дүгээр хавсралт



№	Овог нэр	Албан тушаал
1	Б.Отгончимэг	Бага ангийн багш
2	М.Өсөхцэнгэл	Бага ангийн багш
3	Д.Мөнхгэрэл	Бага ангийн багш
4	Д.Золбоосүрэн	Бага ангийн багш
5	Т.Тунгалагнаран	Бага ангийн багш
6	Ж.Мандах	Бага ангийн багш
7	Г.Гантуяа	Хими биологийн багш
8	Э.Ганбаатар	Дизайн технологийн багш
9	П.Эрдэнэсүрэн	Түүх, нийгмийн ухааны багш
10	Ж.Нандин-Эрдэнэ	МХУЗ-ын багш
11	Ц.Оюу-Эрдэнэ	Гадаад хэлний багш
12	Р.Энхдуулиан	Биеийн тамирын багш
13	С.Баатардорж	Хөгжмийн багш

Ерөнхий боловсролын сургуулийн
захирлын 20.4. оны 1 дугаар сарын 1-ны
өдрийн 1/12 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



20

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ариунаа -Сургалтын менежер

Нарийн бичиг : Ж.Мандах – Бага ангийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн дарга

Гишүүд: Б.Адъяахүү - Нийгмийн ажилтан

Л.Мөнхцэцэг- Математикийн багш


П.Эрдэнэсүрэн- Дунд ангийн мэргэжлийн
хөгжлийн бүлгийн дарга

Т.Жаргал- 5а ангийн сурагч

Ө.Солонго – 9а ангийн сурагч

В.Отгонбаяр- Бага ангийн эцэг эхийн төлөөлөл

З.Энхбямба-Дунд ангийн эцэг эхийн төлөөлөл



Ерөнхий боловсролын сургуулийн
захирлын 2021 оны 3 дугаар сарын 6-ны
өдрийн 1/12 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
БАГШИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага, албан хаагч
Нэг. Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахаас өмнө			
1	Багшид гүйцэтгэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах "Багшийн болон байгууллагын үнэлгээний баг" томилно. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн сургалтын менежерийн өрөөнд ажиллана.	2025.05.06	Захирал
2	Үнэлгээний багийн гишүүдэд гүйцэтгэлийн үнэлгээний журам, чиглэл, удирдамжийг танилцуулж, ажлын зураглал гаргах.	2025.05.06	Ажлын хэсгийн ахлагч
3	Үнэлгээний багийн гишүүдийн хариуцах, ажлыг тодорхой болгож, хуваарь гаргах.	2025.05.06	Ажлын хэсгийн ахлагч
4	Үнэлгээний багийн гишүүдэд хариуцсан ажлыг гүйцэтгэх алхам, дарааллыг танилцуулах.	2025.05.12	Нарийн бичиг
5	Үнэлгээнд хамрагдах багш бүрд гүйцэтгэлийн үнэлгээний эрх зүй, зохион байгуулалтын баримт бичиг, удирдамж, зөвлөмжийг танилцуулах.	2025.05.13	Ажлын хэсэг
6	Хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах зохицуулалт хийх.	Үнэлгээний хугацаанд	Ажлын хэсэг
7	Анги танхимд шалгалтыг зохион байгуулах хянагч багш, хөндлөнгийн хянагч томилох.	2025.05.12	Ажлын хэсэг
8	Бичгийн шалгалт бүхий цэнхэр хайрцгийг Монгол шуудангаас хүлээн авч захирлын өрөөнд байршуулах, хүлээлгэн өгөх	Тухайн хугацаанд	Сургалтын менежер

Хоёр: Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах явцад

1	Багшийн асуулга	2025.05.16	Сургалтын менежер
2	Захирлын, сургалтын менежерийн нийгмийн ажилтны асуулга	2025.05.20	Нийгмийн ажилтан
3	Цахим шалгалт зохион байгуулах анги танхим бэлтгэх	2025.05.14 -19	Сургалтын менежер
4	Бичгийн шалгалт зохион байгуулах	2025.05.19 -21	Ж.Мандах, Л.Мөнхцэцэг
5	Суралцагчийн асуулга	Хугацаанд нь	П.Эрдэнэсүрэн
6	Эцэг эх, асран хамгаалагчийн асуулга	Хугацаанд нь	З.Энхбямба, В.Отгонбаяр
7	Удирдах ажилтны асуулга	Хугацаанд нь	Б.Адъяахүү
8	Сургалтын орчны стандарт хангалтыг үнэлэх хуудас Ө.Солонго – суралцагч Л.Мөнхцэцэг – Багш З.Энхбямба – эцэг эх, асран хамгаалагч	Хугацаанд нь	Б.Адъяахүү
9	Үнэлгээг зохион байгуулах явцад хоорондоо байнга холбоотой байж, үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэх, шаардлагатай баримт нотолгоог эх хувиар бүрдүүлж ажиллах	2025.05.14– 05.21	Ажлын хэсэг
10	Өргөдөл хүсэлтийг хугацаанд нь хүлээн авч шуурхай шийдвэрлэх	Тухай бүр	Ажлын хэсгийн ахлагч

Гурав. Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсны дараа

1	Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж дууссаны дараа ажлын тайлангаа Маягт дагуу бичиж, аймгийн ажлын хэсгийн нарийн бичгийн даргад цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэх	Хугацаанд нь	Ажлын хэсэг
2	Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан ажлын тайлан, явцын тэмдэглэл, үнэлгээний багийн гишүүдийн гаргасан “Хариуцлагын баталгаа” болон бусад холбогдох	Хугацаанд нь	Ажлын хэсэг

	материалыг шаардлагын дагуу бүрдүүлж, архивын нэгж үүсгэн хадгалах		
--	--	--	--